



**АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2015 оны 08 сарын 31 өдөр

Дугаар А/177

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 49 дүгээр зүйлийн 49.5, 50 дугаар зүйлийн 50.1, дэх заалт, Төрийн өмчийн хорооны 2015 оны 174 дүгээр тогтоолоор батлагдсан Автотээврийн үндэсний төвийн дүрмийн 6.9.6, 6.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Автотээврийн үндэсний төвийн “Ажилтныг шагнаж урамшуулах түүнийг олгох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. “Ажилтныг шагнаж урамшуулах түүнийг олгох журам”-ыг 2015 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Тамгын газар /М.Мөнхбаяр/-т даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Автотээврийн үндэсний төвийн захирлын “Журам батлах тухай” 2014 оны 94 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАГ



Н.ПУНЦАГ

001258

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын
захирлын 2015 оны 18 дугаар сарын
31 өдрийн 41 дугаар тушаалын хавсралт
127



“АЖИЛТНЫГ ШАГНАЖ УРАМШУУЛАХ ТҮҮНИЙГ ОЛГОХ ЖУРАМ”

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Автотээврийн үндэсний төвийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг хангахын тулд үйл ажиллагааг тасралтгүй явуулах, бизнес болон стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх, контрактын гэрээний биелэлтийг хангах, өртөг зардлыг бууруулах, идэвх санаачлагатай ажилласан, ажлын тодорхой үр бүтээл гаргасан, хөдөлмөрийн бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэхэд ажилтнуудын идэвх санаачлагыг дэмжих, оруулсан хувь нэмэр, ажлын үр дүн, бүтээлч байдлыг үнэлж, шагнал, урамшуулал олгоход энэхүү журмыг мөрдөнө.

1.2.Журмын зорилго нь ажлын тодорхой үр бүтээл гаргасан, хөдөлмөрийн сахилга, ажлын цаг ашиглалтын зөрчил гаргаагүй, мэргэжлийн өндөр ур чадвар эзэмшиж, идэвх санаачлагатай ажиллаж байгаа ажилтны хүчин чармайлтыг үнэлэн, бүтээлч хандлагыг урамшуулахад оршино.

1.3.Журмын зорилготой нийцсэн болзлыг хангасан тэргүүний ажилтанг материаллаг болон материаллаг бус урамшууллын хэлбэрээр шагнах ба давтамж нь улирлаас доошгүй хугацаатай байна.

1.4.Ажиллагсдын ажлын гүйцэтгэлийг шударга, ил тод байх зарчмыг баримталж үнэлнэ.

1.5.Ажилтныг шагнаж урамшуулах шийдвэрийг шууд харьяалах газар, хэлтэс, тасаг, төвийн даргын саналыг үндэслэн захирал гаргах бөгөөд хамт олонд тухай бүр мэдээлнэ.


Хоёр. Шагнал, урамшуулалын төрлүүд ба хэмжээ

2.1.Төр, салбарын яамдын шагналыг дагалдуулан олгох мөнгөн шагнал. Салбарын хөгжилд хөдөлмөрийн их хувь нэмэр оруулан өндөр амжилт гаргаж төр, салбарын яамдын шагналаар шагнуулсан ажилтанд мөнгөн шагналыг Захирлын тушаалаар олгоно. Үүнд:

2.1.1.“Хөдөлмөрийн баатар” цол хүртсэн бол 700.000 /Долоон зуун мянга/төгрөг;

2.1.2. Төрийн соёрхол хүртсэн бол 600.000 /Зургаан зуун мянга/ төгрөг;

2.1.3.“Ардын” цол хүртсэн бол 500.000 /Таван зуун мянга/ төгрөг;



2.1.4. “Гавьяат” цол хүртсэн бол 400.000 /Дөрвөн зуун мянга/ төгрөг;

2.1.5. “Чингис хаан” одонгоор шагнагдсан бол 300.000 /Гурван зуун мянга/ төгрөг;

2.1.6. “Сүхбаатарын одон” – оор шагнагдсан бол 250.000 /Хоёр зуун тавин мянга/ төгрөг;

2.1.7. “Хөдөлмөрийн гавьяаны улаан туг”-ийн одонгоор шагнагдсан бол 200.000 /Хоёр зуун мянга/ төгрөг

2.1.8. “Алтан гадас” – одонгоор шагнагдсан бол 150.000 /Нэг зуун тавин мянга/ төгрөг;

2.1.9. “Хөдөлмөрийн хүндэт” медалиар шагнагдсан бол 100.000 /Нэг зуун мянга/ төгрөг;

2.2. Салбарын тэргүүний цол, тэмдэг, яамдын жуух бичгээр шагнагдсан тохиолдолд холбогдох журмын дагуу байгууллагаас олгох дагалдах мөнгөн шагналыг Засгийн газрын тогтоолд заасан хэмжээгээр олгоно.

2.3. Газар, хэлтэс, тасаг, төвүүдийн /салбар/ улирал, хагас жилийн ажлын гүйцэтгэлийг дараа сарын 10-ны дотор, бүтэн жилийн ажлын гүйцэтгэлийг тухайн оны 12-р сарын 25-ны дотор тус тус өссөн дүнгээр гаргаж, шагнал урамшууллыг Захирлын тушаалаар олгоно.

2.4. Хагас, бүтэн жилийн орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлж, ашигтай ажилласан бол тухайн газар, хэлтэс, төв, тасагт /салбар/ төлөвлөгөөнөөс давсан орлогын 50 хүртэл хувийг урамшуулал болгон олгох;

2.5. Байгууллагын ашиг, орлогыг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах чиглэлээр инновацийн бүтээлч санал санаачлага дэвшүүлсэн, оновчтой бүтээл /технологи/ гаргаж нэвтрүүлсэн ажилтанд тухай бүрт санаачилсан ажлаас олсон цэвэр ашгийн 30 хүртэлх хувийг шагнал болгон нэг удаа олгох;

2.6. Онц чухал буюу түвэгтэй үүрэг, даалгаврыг амжилттай гүйцэтгэсэн бол нэг удаа албан тушаалын нэг сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох;

2.7. Автотээврийн салбарт олон жил ажиллаж байгаа ажилтны ажлын үр дүн, гаргасан амжилтыг олон нийтэд мэдээлэн алдаршуулах, байгууллагын нэрэмжит хүндэт өргөмжлөл, 50000 /тавин мянган/ төгрөгийн мөнгөн шагнал олгох;

2.8. Үйлдвэрийн газарт олон жил тогтвор суурьшилтай ажиллаж байгаа ажилтны 50, 60 насны ойг тохиолдуулан 100 000 /нэг зуун мянга/ төгрөгийн, ахмадын хороонд бүртгэлтэй ахмад настангуудын 80, 90, 100 насны ойг тохиолдуулан 100 000 /нэг зуун мянга/ төгрөгийн үнэ бүхий зүйл дурсгах буюу мөнгөн урамшуулал олгох;

2.9. Бүх нийтээр тэмдэглэх олон улсын эмэгтэйчүүдийн баярын өдрийг тохиолдуулан тус байгууллагын нийт эмэгтэйчүүдэд тус бүр 15 000 /арван таван мянга/ төгрөг хүртэл, хүүхдийн баяраар нийт албан хаагчдын 16 хүртэлх насны хүүхдэд тус бүр 25 000 /хорин таван мянга/ төгрөг хүртэл бэлэг дурсгалын зүйл буюу мөнгөн урамшуулал олгох;



2.10. Үйлдвэрийн газартай ажил төрлийн уялдаа, холбоотой бусад аж ахуйн нэгж, байгууллагын тэмдэглэлт ой, баяр ёслолыг тохиолдуулан холбогдох арга хэмжээнд зориулан 150 000 /нэг зуун тавин мянга/ хүртэлх төгрөгийн үнэ бүхий зүйл дурсгах буюу мөнгөн урамшуулал олгох;

2.11. Ажлын үр дүнгээр хамт олноо манлайлсан, Онц чухал буюу түвэгтэй үүрэг, даалгавар амжилттай гүйцэтгэсэн, Байгууллагын ашиг, орлогыг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах чиглэлээр инновацийн бүтээлч санал санаачлага дэвшүүлсэн, оновчтой бүтээл /технологи/ гаргаж нэвтрүүлсэн ажилтныг дотоод, гадаадын их дээд сургууль, бусад сургалтанд суралцах эрхээр урамшуулах;

2.12. Засгийн газраас тогтоосон мэргэжлийн тэмдэглэлт өдрөөр тухайн ажил, мэргэжлээр ажиллаж буй ажилтнуудын дундаас мэргэшил, эзэмшсэн ур чадвараараа хамт олондоо хүлээн зөвшөөрөгдсөн манлайлагчийг тодруулан алдаршуулах материаллаг бус урамшууллын арга хэмжээ авч болно.

2.13. Бүтээмжийн хөдөлгөөнийг өрнүүлэхэд идэвхтэй оролцож хамт олноо манлайлан шинэ арга барил эзэмших, инновацийн бүтээлч санал санаачлага дэвшүүлэх, ажлын байрны хөдөлмөрлөх орчинг цэгцлэх дадлыг бүрэн хэмжээгээр эзэмшсэн ажилтныг урамшуулах зорилгоор дотоод, гадаадын компаниудад хэрэгжүүлж буй бүтээмжийн ажилтай танилцах, туршлага судлах, сургалтанд оролцуулах хэлбэрээр шагнаж болно.

Гурав. Шагнал, урамшуулал олгох ажлыг зохион байгуулах

3.1. Ажилтныг шагнаж урамшуулах шийдвэрийг шууд харьяалах газар, хэлтэс, тасаг, төвийн /салбар/ даргын саналыг үндэслэн захирал гаргах бөгөөд хамт олонд тухай бүр мэдээлнэ.


3.2. Газар, хэлтэс, тасаг, төвийн /салбар/ дарга нь ажилтнуудыхаа ажлын үр дүнг хагас болон бүтэн жилээр тооцон гаргаж ажилтанд олгох урамшууллыг Тамгын газар, Санхүү хөрөнгө оруулалтын газраар хянуулан баталгаажуулна.

3.3. Газар, хэлтэс, алба, төвийн /салбар/ дарга нь хариуцсан чиг үүргийнхээ хүрээнд Үйлдвэрийн газрын үр ашгийг нэмэгдүүлэх оновчтой шийдэлд хүрэх бүтээлч санаачлага, түүнийг хэрэгжүүлэхэд хүчин чармайлт гаргасан ажилтанг шагнах саналыг Тамгын газарт бичгээр хүргүүлнэ.

3.4. Онцгой идэвх зүтгэл, санаачлага гарган ажиллаж, жилийн ажлын үр дүнгээр хөдөлмөрийн амжилт гаргасан ажилтныг Төрийн дээд шагнал, одон, медаль, Засгийн газрын хүндэт өргөмжлөлөөр шагнуулах ажилтны саналыг Тамгын газар гаргана.

3.5. Тамгын газар нь газар, хэлтэс, төв, салбарын ирүүлсэн шагналын саналыг нэгтгэн Захирлын зөвлөлийн хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлнэ.

3.6.Газар, хэлтэс, тасаг, төвүүдийн /салбар/ дарга нар ажилтнуудад олгох үр дүнгийн урамшууллын хувь хэмжээг хамт олны хурлаар хэлэлцүүлж, шагнал, урамшуулал олгох буюу олгохгүй байх эрх эдэлнэ.



Дөрөв. Шагнал, урамшуулал олгох болон олгохгүй байх үндэслэл

4.1.Ажилтанд шагнал, урамшуулал олгохдоо дараах шаардлага хангасан ажилтанд олгоно.

4.1.1. Үндсэн ажилтан байх;

4.1.2. Ажлын байрны тодорхойлолтод заагдсан ажил үүргээ бүрэн биелүүлсэн байх;

4.1.3. Ажлын цаг ашиглалт зөрчилгүй байх;

4.1.4. Сахилгын шийтгэл хүлээгээгүй байх;

4.1.5. Байгууллагын дотоод журам болон бусад дүрэм журмыг чанд баримтлан ажиллаж, зөрчил дутагдал гаргаагүй байх;

4.1.6. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлсэн байх;

4.1.7. Өр дутагдал гаргаагүй байх;

4.2. Дараах тохиолдолд шагнал урамшуулал олгохгүй

4.2.1. Ажлын байрны тодорхойлолтод заагдсан үндсэн үйл ажиллагааг цаг хугацаанд гүйцэтгээгүй, удирдах албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврыг бүрэн биелүүлээгүй;

4.2.2.Газар, хэлтэс, тасаг, төвийн /салбар/ ажлын гүйцэтгэл 70 хувиас доош үнэлгээ авсан;

4.2.3. Ажилтан ажлаас чөлөөлөгдсөн, хөдөлмөрийн гэрээ цуцлагдсан;

4.2.4.Газар, хэлтэс, тасаг, төв /салбар/ нь тогтоосон хугацаанд ажлын төлөвлөгөө, үйл ажиллагааны тайлангаа ирүүлээгүй;

4.2.5.Төсөвлөгдсөн зардлыг хэтрүүлэн үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс хэтэрсэн бараа материалын сонголт хийсэн;

4.2.6.Хууль хяналтын, удирдах болон дээд байгууллагын шалгалтаар зөрчил дутагдал гаргасан нь тогтоогдсон;

4.3.Үйлдвэрийн газрын хөдөлмөрийн дотоод журмыг зөрчиж ёс зүйн болон сахилгын зөрчил гаргасан ажилтанд сахилгын шийтгэл ногдуулсан тухай тушаал гарсан өдрөөс эхлэн нэг жилийн хугацаанд шагнал олгохгүй бөгөөд онцгой тохиолдолд захирлын шийдвэрээр шагнал урамшуулал олгож болно.

Тав. Хариуцлага тооцох

5.1.Энэхүү журмын холбогдох заалтуудыг газар, хэлтэс, тасаг, төв, салбартаа хэрэгжүүлээгүй, ажиллагсдын ажлын гүйцэтгэлийг бодитой бус дүгнэсэн, хугацаа хожимдуулсан албан тушаалтанд хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээнд заасан хариуцлага хүлээлгэнэ.

5.2. Тогтоосон хугацаанд ажлын гүйцэтгэл, үйл ажиллагааны тайлангаа ирүүлээгүй газар, хэлтэс, тасаг, төв/салбар/ нь үр дүнгийн урамшуулалд хамрагдахгүй.



-----oO-----